



“ЦЭЭЦЭЭ-ИМПЕКС” ХХК

Нийслэлийн Байгаль орчны
газарт

Монгол улс, Улаанбаатар хот-1235, Чингэлтэй
дүүрэг 19-р хороо, Шадивлан 1-90 404 тоот,
Утас: 976-91915431

Э-шуудан: www.tsetsee_impex@yahoo.com

2022.10.31 № 124

танай _____-ны № _____ -т

Хүсэлт гаргах нь

Манай компани Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутагт орших MV-007134 тоот тусгай зөвшөөрөлтэй “Их булаг”-ийн барилгын чулууны ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлж байна.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлантай танилцаж дүгнэлт гаргаж өгнө үү.

ХҮНДЭТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/Э.ГАНТУЯА/

“Цээцээ импекс” ХХК

**Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт
орших “Их булаг”-ийн барилгын чулууны ордын
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-007134/

/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар: 5455979/

Хянасан:

“НБОГ”, ХБОБНХэлтэсийн мэргэжилтэн:/Ж.Батзолбоо/

Биелэлтийн тайлагнасан:

“Цээцээ импекс” ХХК -ийн

Гүйцэтгэх захирал: / Э.Гантуяа /

Байгаль орчны мэргэжилтэн: *З.Болорцэцэг* *З.Болорцэцэг*

Улаанбаатар хот

2022 он

ГАРЧИГ

ОРШИЛ	3
НЭГ.ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн гол зорилт	5
1.2. БОМТБТ-ний бүтэц	6
ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
2.1. Төлөвлөгөөний нэр	7
2.2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	7
2.3.Төслийн зорилго.....	7
2.4.Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	7
2.5. Төслийн байршил.....	7
2.6. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	8
2.7. Төслийн үйлдвэрлэлийн нөөц.....	8
2.8. Ил уурхайн ашиглалтын технологи	9
2.9. Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц	9
2.10. Төслийн хүчин чадал	9
2.11. Нийгэм, эдийн засгийн үр өгөөж.....	9
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
3.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	11
3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
Нийслэлийн байгаль орчны газраас санал болгосон Хан-уул дүүргийн 14-р хороо Өлзийт хорооны урд Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт зардлаар мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн баримтыг хавсаргав.	13
3.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	13
3.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	13
3.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	13
3.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15
3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	15
3.8. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт....	16
3.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	20
3.12.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт зарсан зардал	21
ДҮГНЭЛТ	22
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ	22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1. Үзүүлэлт /”Цээцээ Импекс” ХХК/.....	7
Хүснэгт № 2. Уурхайн солбилцол.....	8
Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..	11
Хүснэгт № 4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
Хүснэгт № 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	14
Хүснэгт № 6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	15
Хүснэгт № 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	16
Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллана.	16
Хүснэгт № 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	16
Хүснэгт № 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг.....	8
Зураг 2. Тээвэрлэлтийн замыг услаж буй фото зургууд.....	12
Зураг 3. Уурхайн замын тэмдэгжүүлэлтийн фото зургууд.....	12
Зураг 4. Галын булан, аюулгүй ажиллагааны самбаруудын фото зургууд.....	14
Зураг 5. Галын булан, гал унтраах хэрэгслүүдийн фото зургууд.....	14
Зураг 6. Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж буй байдал	15
Зураг 7. Ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас олгосон байдал.....	17
Зураг 8. Эмчийн үзлэгт орж байгаа байдал	17
Зураг 9. ХАБЭА-н сургалтанд хамрагдаж байгаа байдал.....	18
Зураг 10. Үйлдвэрийн бүс бутлуурын хэсгээс 10 метр зайгаас авсан фото зураг	20
Зураг 11. Суурьшилын бүс Үйлдвэрээс 1200 метр зайд үйлдвэр лүү явах шороон замаас 10 метр зайгаас авсан фото зураг	20

ОРШИЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан /гол болон сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт/, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт зэргээс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

БОМТБТ –ний зорилго: “Цээцээ импекс” ХХК –ийн барилгын чулууны уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай ажлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд тайлагнахад оршино.

“Их булаг” барилгын чулууны орд нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төслийн үйл ажиллагааны бүхий л үе шат бүрт байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Цээцээ Импекс” ХХК-ний авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн дагуу боловсруулав.

“Цээцээ Импекс” ХХК-нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны Гачуурт тосгоны нутаг дэвсгэрт орших MV-007134 тоот тусгай зөвшөөрлийн талбайтай “Их булаг” барилгын чулууны ордыг ашиглах төслийг 2014 оны 3-р улирлаас эхлэн олборлолтын үйл ажиллагаа явуулсан байна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29–ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

“Их булаг” барилгын чулууны ордын БОМТ-нд 2022 онд нийт 17,5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

НЭГ.ТАНИЛЦУУЛГА

1.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн гол зорилт

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн ажлын гол зорилго нь “Их булаг”–ийн барилгын чулууны ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ундны усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг авсан,
- Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих, хугацаа, хариуцах эзэнг тогтоосон,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлсон,
- Шаарлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож сөрөг нөлөөллөөс сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

1.2. БОМТБТ-ний бүтэц

БОМТБТ-ний бүрэлдэхүүнд 3 бүлэг, 6 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Танилцуулга: Тухайн төлөвлөгөөний танилцуулга
3. Зорилго: Тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн
4. Төслийн тодорхойлолт: Тухайн төслийн ерөнхий мэдээллийг товчлон оруулав.
5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт
 - Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
 - Нөхөн сэргэ элтийн төлөвлөгөөний биелэлт
 - Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
 - Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
 - Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
 - Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
 - Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь
6. Дүгнэлт

ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төлөвлөгөөний нэр

“Их булаг” –ийн барилгын чулууны ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

2.2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага

“Цээцээ импекс” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011137041

2.3. Төслийн зорилго

“Их булаг” ордын барилгын чулууг олборлож, бутлан ангилан, сайн чанарын дайрга зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

2.4. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт № 1. Үзүүлэлт /“Цээцээ Импекс” ХХК/


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Цээцээ Импекс” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011137041	
3	Уурхайн нэр	“Их булаг”	
4	Ордын нэр	“Их булаг”	
5	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар
6		Сум/Дүүрэг	Баянзүрх
7	Ашигт малтмалын төрөл	Барилгын чулуу	
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-007134	
9	Ашиглалт эхэлсэн огноо	-	
10	Компанийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
11		Сум/Дүүрэг	Чингэлтэй
12		Баг/Хороо	19-р хороо
13		Гудамж/Байр	Шадивлан 1-90 404 тоот
14		Утас	976-11-461757
15		Гар утас	94005431
16	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Э.Гантуяа
17		Гар утас	91915431
18		Электрон шуудан	Tseestee_impex@yahoo.com

2.5. Төслийн байршил

“Их булаг” барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны Гачуурт тосгоны нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 20 км зайд оршино (1-р зураг).

Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй талбайн захын цэгүүдийн солбицол:

№	Уртгаг	Өргөрөг
1.	107° 06' 41,49"	47° 55' 26,78"
2.	107° 06' 11,39"	47° 55' 26,78"
3.	107° 06' 11,39"	47° 56' 31,79"
4.	107° 06' 41,49"	47° 56' 31,79"



Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг

2.6. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших “Их булаг” нэртэй 125 га талбай бүхий ашигт малтмалын MV-007134 дугаартай тусгай зөвшөөрлийг 2002 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр “Цээцээ Импекс” ХХК-нд олгосон байна.

2.7. Төслийн үйлдвэрлэлийн нөөц

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших “Их булаг” нэртэй 125 га талбай бүхий ашигт малтмалын MV-007134 дугаартай тусгай зөвшөөрлийн барилгын чулууны ордын үйлдвэрлэлийн нөөц нь 2013 онд “Цээцээ Импекс” ХХК нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт “Их булаг”-ын ордод эрэл үнэлгээ, хайгуулын ажлыг явуулж, улмаар 2013 оны 12 дугаар сарын 24-ны өдөр нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн

тайланг Уул Уурхайн Яам, Ашигт Малтмалын Газрын дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн В зэрэглэлийн 14.86 сая.м³, С зэрэглэлийн 4.47 сая.м³, нийтдээ 19.34 сая.м³ барилгын чулууны нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

2.8. Ил уурхайн ашиглалтын технологи

Уурхайн оновчтой хүрээ, хязгаарыг тооцоход уурхайн нийт эзлэхүүн 6196.4 мян.м³, түүн дэх алт агуулсан элсний нөөц 302.48 мян.м³, нийт хөрс 5893.9 мян.м³ гарч байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 19.48 м³/м³ байна.

2.9. Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц

2013 онд “Цээцээ Импекс” ХХК нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт “Их булаг”-ын ордод эрэл үнэлгээ, хайгуулын ажлыг явуулж, улмаар 2013 оны 12 дугаар сарын 24-ны өдөр нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Уул Уурхайн Яам, Ашигт Малтмалын Газрын дэргэдэх Эрдэс Баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн В зэрэглэлийн 14.86 сая.м³, С зэрэглэлийн 4.47 сая.м³, нийтдээ 19.34 сая.м³ барилгын чулууны нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

2.10. Төслийн хүчин чадал

Их булаг уурхайн хүчин чадлыг захиалагч компаниас өгсөн техникийн даалгавар, борлуулалтын гэрээ, ашиглах техникүүдийн хүчин чадал одоогийн байдалд тулгуурлан тооцсон. Ил уурхайн жил бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба жилд хамгийн ихдээ 300.0 мян.м³ (сийрэгжээгүйгээр) барилгын чулуу олборлохоор тооцлоо. Их булаг уурхайн хөрс хуулалт, олборлолтын ажлыг 2020 оны 4 сараас эхлэхээр төлөвлөсөн байна. Ил уурхайн барилгын чулуу олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход 57 жилийн хугацаанд олборлохоор байна.

2.11. Нийгэм, эдийн засгийн үр өгөөж

“Их булаг” ордыг ашиглах хугацаанд нийт 14.48 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх ба үүнээс эхний ээлжийн хөрөнгө оруулалт болох 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг “Цээцээ импекс” ХХК нь шийдсэн ба үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулахад бэлэн байна.

Уурхайн ашиглалтын 57 жилийн хугацаанд 235.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 159.2 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган ажиллаж 49 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Ашиглалтын 57 жилийн хугацаанд нийт 63.5 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно.

Уурхайн ашиглалтын эхний 10 жилийн хугацаанд 40.84 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 27.7 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган ажиллаж 8.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах ба 11 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 10 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 1.5 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 35% байна, хөрөнгө оруулалтаа 2.7 жилд нөхнө.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн ажил	2022 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /төгрөг/	Биелэлт
Агаарын чанар			
1	Ордын дотоод тээвэрлэлтийн замыг тоосжилт ихтэй үед усалж байх	-	Тээвэрлэлтийн зам, уурхай, кемп орчмыг тоосжилтоос сэргийлж тогтмол усаар шүршиж, усалж байсан.
2	Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах,	1,900.0 /14*135,000	ТЭЗҮ тусгагдснаар нийт төслийн үйл ажиллагаанд 14 ш машин ажиллуулна. Машинны маркаасаа хамаарч өөр өөр үнэтэй үзлэгт хамруулсан бөгөөд дундаж үнээр тооцоолж гаргасан. Техникийн үзлэгт хамруулсан баримтыг хавсаргав.
3	Засвар үйлчилгээг тогтмол хийх	800.0	Хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулж, засвар үйлчилгээг тогтмол хийлгэсэн
Гадаргын ба газрын доорх усны нөөц			
1	Ус ашигласны төлбөрийг зохих журмын дагуу тооцож орон нутгийн байгууллагад цаг хугацаанд нь төлөх	366.4	Ус ашиглах гэрээ байгуулсан тус компанийн зүгээс ус ашиглах төлбөрийг тогтмол төлж байсан. Усны мөнгийг төлсөн баримтыг хавсаргав.
2	Шатах тослох материал алдагдах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Дотоод төлөвлөлтөөр	Компанийн дотоод журамд байгалийн гэнэтийн эрсдэлийг урьдчилан тооцох, учирсан тохиолдолд яаралтай авах арга хэмжээний хөтөлбөр боловсруулан оруулсан.
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч			
1	Эвдрэлд өртсөн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх	-	2022 онд нөхөн сэргээлт хийгдэхгүй.
2	Зам арчилгааны зардал, эвдэрсэн тохиолдолд засах	Дотоод төлөвлөлтөөр	Эвдэрсэн зам талбай байхгүй. Эвдэрсэн тохиолдолд цаг тухай бүр засвар хийнэ.
3	Үйлдвэрлэлийн технологийн замын зураг гаргаж зөвхөн заасан замаар машин техникүүдийг зорчуулах,	Дотоод төлөвлөлтөөр	Машин техникүүд заагдсан замаараа зорчиж байгаа. Замын тэмдэг тэмдэглэгээний зургийг хавсаргав.
4	Ил уурхайн талбайн хэмжээнээс хэтэрч ажиллахгүй байх	Дотоод төлөвлөлтөөр	Ил уурхайн талбайн хэмжээндээ ажиллаж байгаа.
Ургамлан нөмрөг			
1	Тоос үүсэх талбайг услах, олон салаа зам гаргахгүй гаргасан замаараа зорчих	-	Уурхайн зам талбайн тэмдэгжүүлэлтийн зургийг оруулав.
Нийт			3,066.400



Зураг 2. Тээвэрлэлтийн замыг услаж буй фото зургууд



Зураг 3. Уурхайн замын тэмдэгжүүлэлтийн фото зургууд

3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт № 4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилго	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Жилийн төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэгч	Биелэлт
1	Унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах	ХУД 14-р хороо Өлзийт хорооны урд ДХ-ын төлөвлөгөөний төсөвт зардлаар мод тарих	106°42'55.58"E 47°46'16.25"N 106°43'06.54"E 47°46'13.73"N 106°43'04.77"E 47°46'16.89"N 106°42'53.95"E 47°46'20.19"N	5,955.0	“Цээцээ импекс” ХХК,	Нийслэлийн БО-ны газрын гаргасан саналын дагуу НБОГ-ын харьяа Өлзийт хорооны урд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт ажилд хандив өгсөн. Санал болон уг хийгдсэн ажлын тайланг хавсаргав.
Нийт зардал				5,955.0		

Нийслэлийн байгаль орчны газраас санал болгосон Хан-уул дүүргийн 14-р хороо Өлзийт хорооны урд Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт зардлаар мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн баримтыг хавсаргав.

3.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Их булаг” барилгын чулууны ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

3.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


“Их булаг” барилгын чулууны орд ашиглах уурхайн эдэлбэр газрын ойр орчимд түүх, дурсгалын зүйлс болон археологи, палентлогийн олдвор илрээгүй. Хэрэв уурхайн эдэлбэр газрын хүрээнд түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд дүүрэг хорооны захиргаанд болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулан хамтран ажиллана.

3.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Хүснэгт № 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн ажил	2022 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	-	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж хяналт тавьж ажилласан.
2	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардалд багтсан	Ажилчдад галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан. Ажилчдын байр зэрэг зохих
3	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Үйл ажиллагааны зардалд багтсан	газруудад гал унтраах хэрэгслүүдийг байрлуулж, самбар тэмдэг тэмдэглэгээг хадсан.



Зураг 4. Галын булан, аюулгүй ажиллагааны самбаруудын фото зургууд



Зураг 5. Галын булан, гал унтраах хэрэгслүүдийн фото зургууд



Зураг 6. Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж буй байдал

3.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт № 6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн ажил	Биелэлт	2022 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /мян.төг/
1	Болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх	“Power blast” ХХК-ийн мэргэжлийн инженерүүд гэрээгээр хариуцан гүйцэтгэдэг. Тэсэлгээний ажлын аюулгүй байдлыг гэрээт компани тусгай төлөвлөгөөний дагуу хариуцан ажилладаг үүргийн дагуу тэсрэх бодистой аюулгүй ажиллах дүрмийг баримтлан ажилладаг.	“Power blast” ХХК-тай хийсэн гэрээг хавсаргав.
2	Тэсрэх бодисыг хадгалах, ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад сав баглаа боодол задарч асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх		
3	Тэсрэх бодис асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг бэлтгэж бэлэн болгох		
4	Ашиглагдсан тэсрэх бодисын сав баглаа боодлыг орон нутгаас зааж өгсөн талбайд булшлах, устгах арга хэмжээ авах		

3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Цээцээ Импекс” ХХК нь Баянзүрх дүүргийн 20–р хорооны “Дэд бүтэц, тохижилтын хэлтэс”-тэй тохижилт, цэвэрлэгээний гэрээ байгуулан ажилладаг бөгөөд хог хаягдлыг тухай бүрт гэрээний дагуу тээвэрлэдэг. Мөн Их булгийн амны айлуудын хогийн цэгийг байнга цэвэрлэдэг.

Хүснэгт № 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн ажил	2022 онд БОМТБ – нд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний дагуу хогийг цаг хугацаанд нь тээвэрлүүлж байх	150.0	“БЗД-ийн хог тээвэрлэх компанитай гэрээ байгуулан сар бүр тээвэрлүүлдэг. Гэрээг хавсаргав.
Нийт		150.0	

3.8. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллана.

Хүснэгт № 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн ажил	2022 онд БОМТБ – нд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны зардалд орсон	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр бүрэн хангасан
2	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах		Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан.
3	Ажиллагсдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	1,684.4	Ажилчдыг эмчийн үзлэгт хамруулсан зургийг хавсаргав.
4	БОМТ-ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч байх	-	БОМТ-ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч ажиллаж байна.
5	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	5,500.0	Байгаль орчны аудитыг “Мон газар консалтинг” ХХК-иар хийлгүүлсэн тайлангийн нүүрийг хавсаргав.
Нийт		7,184.4	



Зураг 7. Ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас олгосон байдал



Зураг 8. Эмчийн үзлэгт орж байгаа байдал



Зураг 9. ХАБЭА-н сургалтанд хамрагдаж байгаа байдал

3.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Цээцээ импекс” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасадаг баримт бичиг юм.


“Их булаг” –ийн барилгын чулууны ордын төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ. Тухайн төслийг хэрэгжүүлэх явцад ус, хөрс, агаарт үүсэх бохирдол, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг бүрт орох аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц дээж авах болон хэмжилт хийх цэгийн байршил, шинжилгээгээр тодорхойлох үзүүлэлтүүд шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах хэлбэр зэргийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нарийвчлан тусгана. Үүний дагуу “Цээцээ импекс” ХХК нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох ус, хөрс, агаарт БОМТ-нд тусгасны дагуу хяналт шинжилгээг зайлшгүй хийх шаардлагатай.

БОХШХ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно.

“Их булаг” барилгын чулууны ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлсны дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

Хүснэгт № 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлтүүд	Биелэлт	Зардал /мян.төг/
Агаарын орчин			
1	Агаар дахь (TSP, PM10, PM2,5) ханаагүй тоосны дээж авч шинжлүүлэх	Бутлуур, дотоод тээвэрлэлтийн замаас, ил уурхайгаас дээж авч шинжилгээ хийлгүүлсэн.	1,146.4
2	Дуу чимээ, агаарын чийгшил, хөрсний температур хэмжих	Бутлуур, ил уурхай, уурхайн кемп суурьшилын бус буюу үйлдвэрээс 1200 метр орчмоос дуу шуугианы дээж авч “Хэлт энд сэфти солушинс” ХХК-ны эрүүл ахуй хор судлалын лаборатороор хийлгүүлсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргав.	
Хөрс			
3	-Хөрсний химийн үзүүлэлт (рН, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃) -Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	Уурхайн карьерийн гадна талаас зонхилох салхины чиглэлийн дагуу болон шатах тослох материалын агуулах, бохирдсон байж болох цэгүүдээс хөрсний дээж авч ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хөрсний шинжилгээний лабораториудад шинжлүүлсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргасан	Хөрсний ерөнхий шинжилгээ хүнд метал- 46.0
Ус			
3	-Усны химийн шинжилгээ (рН, EC, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Ахуйн хэрэглээний уснаас ерөнхий шинжилгээ авсан. Ундны уснаас дээж авч ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргасан	30,0
Нийт			1,222.4



Зураг 10. Үйлдвэрийн бүс бутлуурын хэсгээс 10 метр зайгаас авсан фото зураг



Зураг 11. Суурьшилын бүс Үйлдвэрээс 1200 метр зайд үйлдвэр лүү явах шороон замаас 10 метр зайгаас авсан фото зураг

3.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

Хүснэгт № 10. БОМТБ-ийн хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Мэдээний агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар	Биелэлт
1	БОМТ-ний биелэлтийг сум /БЗД/ орон нутагт тайлагнах	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	БОАЖЯ болон сум /БЗД/орон нутагт	ИТХурал болон дүүргийн иргэдэд тайлагнасан.
2	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	БОАЖЯ-нд	БОАЖЯ-нд БОМТ-ний тайлан батлуулахаар өгсөн байгаа.

“Цээцээ Импекс” ХХК-ний “Их булаг” –ийн барилгын чулууны орд ашиглах төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөлөөлөлд шууд өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах үүргээ хэрэгжүүлэх зорилготой дараах арга хэмжээг төлөвлөж, биелүүлүүлэн ажиллаж байна.

3.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт зарсан зардал

Хүснэгт № 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт зарсан зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тухайн жилийн БОМТБ-ийн нийт зардал /мян.төг/, 2022 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	3,066.4
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5,955.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	150.0
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	7,184.4
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	1,222.4
Нийт		17,578.2

“Цээцээ Импекс” ХХК-ний “Их булаг” –ийн барилгын чулууны ордыг ашиглах уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд 2022 онд нийт 17,5 сая төгрөг зарцуулсан ба үйл ажиллагааны зардал болон дотоод төлөвлөлтөөр тусгагдсан ажлууд тухайн төсөвт өртгөөрөө хийгдсэн болно.

ДҮГНЭЛТ

“Цээцээ импекс” ХХК ний Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20–р хорооны нутагт орших “Их булаг” барилгын чулууны ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн биелэлтийн тайланг боловсруулан гаргалаа.

“Цээцээ импекс” ХХК нь 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангийн дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг бүрэн авч хэрэгжүүлэн ажилласан байна.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир уурхайн хаалтын дараа нөхөн сэргээлт бүрэн хийгдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд 2022 онд нийтдээ 17,5 сая төгрөг зарцуулсан ба үйл ажиллагааны зардал болон дотоод төлөвлөлтөөр тусгагдсан ажлууд тухайн төсөвт өртгөөрөө хийсэн.

“Цээцээ импекс” ХХК нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангийн дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг бүрэн авч хэрэгжүүлэн ажилласан байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29–ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
2. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших “Их булаг” барилгын чулууны ордын 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал /гарын авлага/ УБ 2014 он



**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 02 сарын 11 өдөр

Дугаар Н-31

Улаанбаатар хот

Нөөц бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 12 дугаар дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны ХХ-24-15 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хуралдааны дүгнэлтийн дагуу хүлээн авсан Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Их булаг нэртэй MV-007134 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах Их булагийн барилгын чулууны ордын нөөцийг Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв архив (Р.Энхсайхан)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г. АЛТАНСҮХ

10 0208

УУЛ УУРХАЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2013 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар ХХ-24-15

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Их булагийн барилгын чулууны ордод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Их булагийн барилгын чулууны ордод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр геологич Н.Энхбаатар, Э.Доржготов, Б.Буянхишиг, С.Амгаланбаатар нарын боловсруулсан тайлан, уг тайлан болон ордын нөөцийн тооцоонд мэргэшсэн инженер, геологич Г.Сугаржавын хийсэн шинжээчийн дүгнэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараахь ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Их булаг нэртэй 125 га талбай бүхий MV-007134 тоот тусгай зөвшөөрлийг АМХЭГ-ын ГУУКА-аас 2004 оны 3-р сарын 23-ны өдөр “Мандал Баян” ХХК-д олгосон байна. Улмаар ГУУКГ-ын даргын 2008 оны 3-р сарын 24-ний өдрийн 380 тоот шийдвэрээр “Цээцээ импекс” ХХК-д шилжүүлснийг бүртгэсэн байна.

Их булагийн талбайд “Цээцээ импекс” ХХК өөрийн хөрөнгөөр 2013 онд хайгуулын ажил гүйцэтгэж, барилгын чулууны бодитой болон боломжтой (В+С) нөөцийг тогтоож, хайгуулын ажилд 146,134,250.0 төгрөг зарцуулсан байна.

Барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт оршдог бөгөөд Улаанбаатар хотоос 20 км-т байрлана.

2. 1925 онд ЗХУ-ын ШУА, БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хорооны хооронд хамтарсан экспедицүүд байгуулагдан судалгаа шинжилгээний ажлыг эхлэн хийсэн байна. 1930 онд БНМАУ-ын Засгийн газрын хүсэлтээр ЗХУ-ын ШУА-ийн ажилтан З.А.Лебедев Улаанбаатар хот болон түүний дүүрэгт 1:1000000-ын масштабтай геологийн зураглалын ажлыг хийжээ. Дээрхи зураглалын ажлын гол зорилго нь Улаанбаатар хот орчимд барилгын материалын түүхий эдийн орд, илрэлүүдийг олж тогтооход чиглэгдсэн байна.

3. Геологийн тогтоцын хувьд барилгын чулууны орд нь доод-дунд карбоны хөхөвтөр саарал өнгийн цахиурлаг алевролит ба элсэн чулуу, орчин үеийн дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаас бүрдэнэ. Ордын талбайн хэмжээнд эдгээр хурдсууд зүүн-хойш 10-20°-ын суналтай ба зүүн-урагшаа 110°-ын азимутаар 20-30°-ын өнцгөөр унасан байгааг тогтоожээ. Цахиурлаг алевролит ба элсэн чулууны үеүд нь нийцлэг байрлалтай бөгөөд ордын зүүн-хойд, зүүн хэсэгт элсэн чулууны давхрагын урт нь 600 м хүртэл үргэлжлэх ба зузаан нь тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 220 м хүртэл байснаа зүүн-урд чиглэлд аажим нарийсч байгааг тогтоожээ. Ордын ихэнх талбайд хөхдүү саарал өнгийн цахиурлаг алевролитын давхрага тархсан байна. Цахиурлаг алевролит нь хөхөвтөр саарал, заримдаа ногоовтор саарал өнгөтэй, жижиг ба дунд ширхэгтэй, цул заримдаа

сулхан занарлаг текстуртэй, микролепидобласт структуртэй байна гэж үзсэн байна. Алевролит нь 25-30% чулуулгийн хэмхдэс, 70-75% цементлэгч хэсгээс тогтох ба аргиллитжих, метаморфжих процесст автагдаж хэмхдэсүүд нь нэг зүгт чиглэж, цемент нь биотит, серицитэт микролепидобласт агрегатад бүрэн шилжсэн байна.

4. Тус компани нь нийт 125 га талбайд 1:2000-ны масштабтай топо-геодезийн зураглалын ажлыг “Хос маркшейдер” ХХК-тай гэрээ хийж хамтран ажилласан байна.

2013 онд нийт 41 цооног өрөмдөж, ордын барилгын чулууны физик-механикийн бүрэн шинжилгээ болон лаборатори-технологийн туршилтыг Барилга архитектур корпорацийн Барилгын материал, Технологийн судалгааны төвийн Керамик, барьцалдуулагч материалын лабораторид, гамма спектрометрийн шинжилгээг Цөмийн судалгааны төвийн лабораторид тус тус хийлгэсэн байна.

Физик механикийн шинж чанарын үзүүлэлтийн бүрэн шинжилгээний үр дүнгээр ордын чулуулгийн бутлагдалт Др 8.9, дайрганы гарц 62.92%, үйрмэг 37.08%, ус шингээлт 1.02%, асгаасан эзэлхүүний нягт 1343.7 кг/м³, тоосорхог агууламж 0.22%, хүйтэн гэсвэрлэлт 2.99% болохыг тогтоожээ.

Химийн найрлага нь сорилтоор SiO₂-68.73%, Al₂O₃-17.07%, Fe₂O₃-6.91%, CaO+MgO-4.8%, K₂O+Na₂O-3.5%, SO₃-0.27% байгаагаас үзэхэд энэ ордын чулуулаг нь дайрганы үйлдвэрлэлийн түүхий эдийн шаардлага хангаж байна гэж үзжээ.

Рентгенграфийн шинжилгээгээр ордын чулуулаг нь шаварлаг хольц, гематит, кальцит агуулсан хээрийн жоншлог чулуулгийн ангилалд багтахыг тогтоосон байна.

Цацрагийн идэвхижилтийн судалгаагаар ордын чулуунд агуулагдах радийн эквивалент нь дунджаар 137.5 Бк/кг байгаа нь байвал зохих хэмжээнээс 2.7 дахин бага байх тул хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж дүгнэжээ.

Ордын чулуугаар бэлтгэсэн дайрга, үйрмэгээр бетоны хольц бэлтгэж туршсан дүнгээс үзэхэд В20, В25 ангийн бетоны үйлдвэрлэлд дүүргэгчээр ашиглах боломжтой гэж дүгнэсэн байна.

5. Их булагийн барилгын чулууны ордод хийсэн хайгуулын ажлын үр дүнгээр бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 19,347,686.0 м³ үүнээс бодитой (В) нөөцийг 14,870,589.4 м³, боломжтой (С) нөөцийг 4,477,097.0 м³ гэж тооцжээ.

Шинжээч дээрхи нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж, зохиогч болон шинжээчийн тооцооны зөрүү зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа тул (В+С) зэргээр тооцсон нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээн авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед гишүүдийн олонхийн саналаар нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзсэн байна.

6. Судалгааны талбайн хэмжээнд булаг шанд, гүний өрөмдмөл худаг байхгүй бөгөөд хэрэглээний усны хэрэгцээг зэргэлдээх суурингаас хангадаг гэжээ. Хайгуулын ажлын явцад 40 м хүртэл гүн өрөмдөхөд уст давхарга илрээгүй байна. Цаашид гидрогеологийн судалгаа хийж ахуйн болон уурхайн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ гэж үзсэн байна.

7. Орд газрыг ашиглах ТЭЗ-ийн урьдчилсан тооцоогоор жилд дунджаар 650.0 м³ барилгын чулуу олборлох, 2,229.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх, 194,580.71 сая

төгрөгийн борлуулалтын орлого олох, 107,966.54 сая төгрөгийн ашиглалтын зардал гаргах, 71,959.5 сая төгрөгийн цэвэр ашиг олох, 5 жилийн дараахь өнөөгийн цэвэр үнэ цэнэ, NPV-10% байхад 19,053.21 сая төгрөг, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2.2 жил, 1 м³ дайрганы бүрэн өөрийн өртөг 7,908.68 төгрөг, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах зардалд 723.05 сая төгрөг гэж тооцсон байна.

8. Цаашид байгаль орчны ерөнхий үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон ТЭЗҮ-ийг эрх бүхий газруудаар хийлгэх, ТЭЗҮ боловсруулахын өмнө гидрогеологийн судалгааг хийж усны асуудлыг бүрэн шийдвэрлэх, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажилд онцгой анхаарч, ашиглалтын явцад түүхий эдийг дундажлах агуулахад сайтар хольж байх, Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг баримталж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчэд анхааруулахаар тогтов.

Тайлан зохиогчдын илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас дараахь дүгнэлтийг гаргав. Үүнд:

1. “Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Их булагийн барилгын чулууны ордод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” (Ордын нөөц 2013 оны 10-р сарын 01-ний байдлаар) дахь Их булаг нэртэй MV-007134 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах Их булагийн барилгын чулууны бодитой болон боломжтой (B+C) нөөцийг 19,347,686.0 м³-ээр үүнээс бодитой (B) нөөцийг 14,870,589.4 м³-ээр, боломжтой (C) нөөцийг 4,477,097.0 м³-ээр зохиогчийн тооцоолсон хувилбараар, хүснэгт-1-ийн дагуу хүлээн авах,

2. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Их булаг нэртэй MV-007134 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах Их булагийн барилгын чулууны ордын нөөцийг Ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв архив (Р.Энхсайхан)-т зөвшөөрөх,

3. Энэхүү дүгнэлтийн 8-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Цээцээ импекс” ХХК -д анхааруулах,

4. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хавсралт зургууд, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн мэдээллийн төв архивт хүлээлгэн өгөхийг “Цээцээ импекс” ХХК даалгах,

5. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших Их булагийн барилгын чулууны орлод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажил, түүний бүх төрлийн дээжлэлт, тайлан боловсруулалтыг геологич Н.Энхбаатар, Э.Доржготов, Б.Буянхишиг, С.Амгаланбаатар нар, барилгын чулууны физик-механикийн бүрэн шинжилгээ болон лаборатори-технологийн туршилтыг Барилга архитектур корпорацийн Барилгын материал, Технологийн судалгааны төвийн Керамик, барьцалдуулагч материалын лаборатори, гамма спектрометрийн шинжилгээг Цөмийн судалгааны төвийн лаборатори, 1:2000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлыг "Хос маркшейдер" ХХК тус тус хариуцах, дээрхи гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг шинжээч мэргэшсэн инженер, геологич Г.Сугаржав, МУ-ын зөвлөх инженер Ч.Сумьяажав нар болон "Цээцээ импекс" ХХК хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА,
УУЯ-НЫ СБТГ-ЫН ДАРГА

Ч. ОТГОЧУЛУУ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН АШИГТ МАЛТМАЛТАЙ
ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ
САЛБАР ХУРАЛДААНЫ ДАРГА,
УУЯ-НЫ БХЗГ-ЫН ДАРГА

Б. БАТХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.НАРАНЦЭЦЭГ

ЭБМЗ-ийн 2013 оны 12 дугаар сарын
24-ний өдрийн ХХ-24 дүгээр хуралдааны ХХ-
24-15 дугаар дүгнэлтийн хавсралт

**Их благагийн барилгын чулууны ордын нөөцийн
тооцооны нэгдсэн хүснэгт**
/MV-007134/

Хүснэгт-1

Д/д	Нөөцийн зэрэг	Блокын дугаар	Блокийн хэмжилтийн талбай /м2/	Барилгын чулууны дундаж зузаан /м/	Барилгын чулууны нөөц /м3/	Хуулах хөрсний зузаан /м/	Хуулах хөрсний эзэлхүүн /м3/	Хуулах хөрсний эзлэх хувь /%/
1	В	Блок.В-1	19519,4	39,10	763256,0	0,9	17518,6	2,30
2		Блок.В-2	19824,8	39,18	776636,6	0,8	16355,5	2,11
3		Блок.В-3	20022,4	39,17	784227,0	0,8	16668,6	2,13
4		Блок.В-4	20947,6	39,08	818684,2	0,9	19219,4	2,35
5		Блок.В-5	21156,3	39,16	828531,7	0,8	17718,4	2,14
6		Блок.В-6	20329,8	39,15	795910,2	0,9	17280,3	2,17
7		Блок.В-7	17578,1	39,13	687742,2	0,9	15380,8	2,24
8		Блок.В-8	38239,0	39,33	1503747,2	0,7	25811,3	1,72
9		Блок.В-9	38009,1	39,21	1490228,6	0,8	30135,8	2,02
10		Блок.В-10	42761,7	39,09	1671370,4	0,9	39096,4	2,34
11		Блок.В-11	20087,5	38,98	782911,1	1,0	20589,7	2,63
12		Блок.В-12	20019,8	39,09	782523,2	0,9	18268,0	2,33
13		Блок.В-13	20142,0	39,15	788559,3	0,9	17120,7	2,17
14		Блок.В-14	20372,1	39,23	799096,1	0,8	15788,4	1,98
15		Блок.В-15	20343,6	39,29	799298,3	0,7	14443,9	1,81
16		Блок.В-16	20371,9	39,17	797867,2	0,8	17010,6	2,13
17	Бүгд "В" зэргээр		379724,9	39,16	14 870 589,4	0,84	318406,4	2,14
18	С	Блок.С-1	6585,3	39,13	257682,8	0,9	5729,2	2,22
19		Блок.С-2	6631,6	39,16	259692,5	0,8	5570,5	2,15
20		Блок.С-3	6573,0	39,13	257201,9	0,9	5718,5	2,22
21		Блок.С-4	6623,5	39,03	258483,2	1,0	6457,9	2,50
22		Блок.С-5	6596,2	39,18	258404,4	0,8	5441,8	2,11
23		Блок.С-6	6718,7	39,18	263205,1	0,8	5542,9	2,11
24		Блок.С-7	9212,2	39,18	360964,3	0,8	7523,3	2,08
25		Блок.С-8	6248,7	39,35	245885,0	0,7	4061,6	1,65
26		Блок.С-9	9001,8	39,07	351668,7	0,9	8401,6	2,39
27		Блок.С-10	6084,1	39,00	237279,5	1,0	6084,1	2,56
28		Блок.С-11	6622,2	38,95	257935,3	1,1	6953,3	2,70
29		Блок.С-12	6539,4	39,08	255526,5	0,9	6048,9	2,37
30		Блок.С-13	6650,8	39,23	260878,4	0,8	5154,4	1,98

31		Блок.С-14	6708,2	39,23	263129,7	0,8	5198,9	1,98
32		Блок.С-15	6646,1	39,26	260891,4	0,7	4951,3	1,90
33		Блок.С-16	10942,9	39,14	428268,0	0,9	9447,4	2,21
34	Бүгд "С" зэргээр		114384,6	39,14	4 477 097	0,86	98285,8	2,20
Ордын хэмжээнд /В+С/			494109,5	39,16	19 347 686	0,84	416692,2	2,15

Нөөцийн тооцоог хийсэн: Н.Энхбаатар, Э.Доржготов нар



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 18, өдөр

Дугаар 7/86.

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн т/20-06-05 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших MV-007134 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Цээцээ импекс ХХК-ийн Их булагийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших MV-007134 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Их булагийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Цээцээ импекс ХХК-д даалгасугай.

ДАРГА



Х.ХЭРЛЭН

53700893



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар Т/20-06-05

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших MV-007134 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Их булагийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай

“Цээцээ импекс” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Цариг ресурс” ХХК-ийн боловсруулсан Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших MV-007134 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Их булагийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол улсын зөвлөх инженер Я.Дэрийлаамятав зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Ц.Оюунбаатар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн нээлт, үйлдвэрлэлийн нөөц, Олборлолт, Уурхайн бутлан ангилах хэсэг, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Уурхайн үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө, Төслийн эдийн засаг зэрэг 11 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 155 хуудас тайлбар бичиг, 21 хавсралт зургаас бүрдэж байна.

2. MV-007134 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Их булагийн барилгын чулууны ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хурлын ХХ-24-15 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн н/31 дүгээр тушаалаар ордын нөөц нь бодитой В зэргээр 14,870.589 мян.м³ барилгын чулуу, боломжтой (С) зэргээр 4,477.097 мян.м³ барилгын чулуу бөгөөд нийт (В+С) зэргээр 19,347.686 мян.м³ барилгын чулууны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Их булагийн барилгын чулууны олборлолтын нөөцийг тооцохдоо 2018 оны ашиглалтын үйл ажиллагааны тайланд үндэслэн бодитой В зэргээр 14,246.84 мян.м³ барилгын чулуу, боломжтой (С) зэргээр 4,402.5 мян.м³ барилгын чулуу бөгөөд нийт (В+С) зэргээр 18,649 мян.м³ барилгын чулууны нөөцтэй гэж тооцжээ.

00002453

4. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо олборлолтын явцад бохирдол болон хаягдал үүсгэн олборлохоор тооцсон байна. Ашиглалтын үеийн хаягдал 1.24%-иар (211.17 мян.м³), бохирдол 1.01%-иар (172.77 мян.м³) тооцсон ба ордыг 57 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 1,383.49 мян.м³ хөрс хуулж, магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 17,025.79 мян.м³ барилгын чулуу олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал сийрэгжээгүйгээр 300.0 мян.м³ барилгын чулуу бөгөөд хөрс хуулалтын дундаж коэффициент 0.08 м³/м³.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн шинж чанар зэргийг харгалзан үзэж авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ. (Жилийн хүчин чадал 300 мян.м³ барилгын чулуу)

6. Тус уурхайд CAT-329DL, CAT-330 DL маркийн экскаватор—2 ширхэг, 25 тн даацтай Howo маркийн автосамосвал-5 ширхэг, Shantui SD-13 маркийн бульдозер-1 ширхэг, Liugong CLG 855 маркийн дугуйт ачигч-1 ширхэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

